**ЕС. МОНГОЛ УЛСЫН ШУА-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2000 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр | Дугаар 78 | Улаанбаатар хот

**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Салбарын Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Бүтээлийг төрийн шагналд нэр дэвшүүлэхэд Шинжлэх ухааны Академийн Бага чуулганы баримтлах журам"-ыг хавсралтын ёсоор батлалсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б. ЧАДРАА

***ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2000 оны 78 дугаар тушаалын хавсралт***

**БҮТЭЭЛИЙГ ТӨРИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХЭД ШУА-ИЙН БАГА ЧУУЛГАНЫ БАРИМТЛАХ ЖУРАМ**

**1. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 08 дугаар зарлигаар шинэчлэн батлагдсан "Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм"-ийн "Шинжлэх ухаан, технологийн бүтээлүүдийг их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлаар

хэлэлцэж, ШУА-ийн холбогдох салбарын Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Бага чуулгануудаас бүтээлийг төрийн шагналд нэр дэвшүүлэх асуудлыг авч хэлэлцэхэд баримтлах дэг горимыг тогтооход оршино.

## 2. Бүтээлийг хүлээн авах, хэлэлцэх

2.1. Бүтээлийг их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн материалын хамт тухайн оны 4 дүгээр сарын 6-ны дотор Шинжлэх ухааны Академийн салбарын Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн даргад ирүүлнэ. Хугацаа хоцорсон материалыг хүлээж авахгүй.

2.2. Нэр дэвшиж байгаа эх бүтээлийг ШУА-ийн Бага чуулганы гишүүдийн тоогоор нэр дэвшүүлэгч өөрөө эсвэл нэр дэвшүүлсэн байгууллага хуралдаан эхлэхээс 14 өдрийн өмнө гишүүдэд тараана.

2.3. Бүтээлийн нэр дэвшүүлэх хуралдааныг бага чуулганы бүх гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн ирцтэйгээр зохион байгуулна.

2.4. Бүтээлийн нэр дэвшүүлэх хуралдаанд зохиогчийг оролцуулна.

2.5. Бага чуулганы хуралдааны тэмдэглэлийг дэлгэрэнгүй тодорхой хөтөлсөн байна. Тэмдэглэлд Бага чуулганы дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

## 3. Бүтээлийг нэр дэвшүүлэх

3.1. Бүтээлийг “Монгол улсын төрийн шагналын тухай дүрэм”-д заасны дагуу хуралдаанд оролцогсдын дөрөвний гурваас доошгүй санал авсан тохиолдолд дэмжигдсэн гэж үзнэ.

3.2. Бүтээлийн нэр дэвшүүлэх саналыг нууцаар хураана.

3.3. Нууцаар санал авч байгаатай холбогдуулан тооллогын комиссыг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Санал хураалтын дүнгийн талаар тооллогын комисс тогтоол гаргана.

3.4. “Монгол улсын төрийн шагналын тухай дүрэм”-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу саналын хуудас, тооллогын комиссын тогтоолыг хуралдааны тэмдэглэлд хавсаргана.

3.5. Төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлийг Монгол улсын төрийн шагналын дүрмийн хавсралтад заасан бүрдүүлвэл зохих баримт бичгүүдийн хамт тухайн оны 4 дүгээр сарын 20-ны дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлнэ.